



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ**

2018 оны 01 дугаар сарын 31

№ 01/04 ДУА-2018/Ч/СТА-ОНТС Мандалговь хот

**Г Төлбөр барагдуулах тухай Г**

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Хулд сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 93,032,985.00 /Ерэн гурван сая гучин хоёр мянга есөн зуун наян таван/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Эвлэрлийн гэрээ хийсэн 6 иргэний 16,526,524.00 /арван зургаан сая таван зуун хорин дөрвөн / төгрөгийн зээлийн үлдэгдлийг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ зохион байгуулаагүй байна.

Энэ нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74<sup>1</sup>.8.-д /Эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захиралжэ энэ хуулийн 75 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна. Энэ захиралжийг талууд сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийн нэг адил албадан гүйцэтгэнэ./, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.-д /Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ үүрэг гүйцэтгэгч биелүүлээгүй бол нөгөө тал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй./ гэж заасныг тус тус зөрчсөн.

1. Төсөл хэрэгжүүлэгч 29 иргэн гэрээнд заасны дагуу үндсэн зээл, зээлийн хүүг төлөлгүй хугацаа хэтрүүлснээс нийт 76,506,461.00 /далан зургаан сая таван зуун зургаан мянга дөрвөн зуун жаран нэгэн / төгрөгийн авлагыг зээлдэгч нар төлөөгүй зөрчил илэрсэн.



Энэ нь Иргэний тухай хуулийн 222 дугаар зүйлийн 222.4.-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна/, 222.5.-т /Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй./, зээлдүүлэгчтэй байгуулсан “Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээ”-ний 2.2-т /Зээлийн үндсэн төлбөрийг дор дурдсан зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж, дуусгана. /Хавсралт-1// гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн

2.2.3-г /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д /Улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, хөтөлбөр, биеэ даасан эрхийн актаар зохицуулагддаг сан хөтөлбөр батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй/ мөн тус журмын 3.1.7-д /Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан/ гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Эвлэрлийн гэрээ хийсний дагуу төлбөрөө төлөөгүй иргэдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлж, зээлийн үлдэгдлийг бүрэн барагдуулах;
2. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн нийт **93,032,985.00** /Ерэн гурван сая гучин хоёр мянга есөн зуун наян таван/ төгрөгийн зээлийн авлагыг нэр бүхий 35 зээлдэгч /Хавсралт 1/ нараар нөхөн төлүүлж, Хулд сумын Сум хөгжүүлэх сангийн Төрийн сан банк дахь 100080955406 дугаар дансанд 2018 оны 5 дугаар сарын 10-ны дотор төвлөрүүлэх.

Актыг тогтоосон хугацаанд бүрэн барагдуулах арга хэмжээ авах, биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Хулд сумын Засаг дарга Ч.Зоригтбаатар, нягтлан бодогч Ч.Хүүхэнбаатар, Сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн Ц.Мөнхсүх нарт хариуцуулав.

	<b>ТОГТООСОН<sup>1</sup>:</b>	<b>АКТЫГ</b>		<b>ЗӨВШӨӨРСӨН:</b>
АУДИТОР	Д.ДОЛЖИНСҮРЭН	ЗАСАГ ДАРГА	Ч.ЗОРИГТБААТАР	
		НЯГТЛАН БОДОГЧ	Ч.ХҮҮХЭНБААТАР	
		СХС ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН	Ц.МӨНХСҮХ	

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

2018 оны 11 сарын 31 Өдрийн  
тоот актыг хавсралт

4817144213

2017.12 сар А0039 9033475

**Хулд сумын сум хөгжүүлэх сангаас хугацаа хэтрэлттэй зээлдэгчдийн жагсаалт**

№	Зээлдэгчийн нэрс	2017.12 сар		2017.12 сар		
		Нийт зээлийн үлдэгдэл		Хугацаа хэтрэсэн		
		Зээлийн авлага	ХҮҮ. алдангийн авлага	Хугацаа хэтрэсэн зээлт	Хугацаа хэтрэсэн хүү алданги	Нийт хугацаа хэтрэсэн зээл, зээлийн хүү, алданги
1	<b>Эвлэрлийн гэрээтэй хүмүүс</b>					
1	Ж.Нармандах	265,000		265,000		265,000
2	Ц.Мөнхтуяа	660,000		660,000		660,000
3	Э.Бат Итгэлт	3,900,000	124,498	3,900,000	124,498	4,024,498
4	Б.Мөнгөнбулга	96,096		96,096		96,096
5	Д.Даваадорж	2,475,000	67,806	2,475,000	67,806	2,542,806
6	Дорждэрэм	8,700,000	238,124	8,700,000	238,124	8,938,124
	Дүн	<b>16,096,096</b>	<b>430,428</b>	<b>16,096,096</b>	<b>430,428</b>	<b>16,526,524</b>
2	<b>Шүүхэд хандах хүмүүсийн жагсаалт</b>					
1	Н.БолорЭрдэнэ	629,325		629,325		629,325
2	Хүрэлбаатар	3,114,364		3,114,364		3,114,364
3	Сосорсүрэн	1,194,595	8,959	1,194,595	8,959	1,203,554
4	Гансүх Х	6,145,000	503,076	6,145,000	503,076	6,648,076
5	Өлзийсайхан	500,000	21,933	500,000	21,933	521,933
6	Ганболд Д	1,191,791	8,938	1,191,791	8,938	1,200,730
7	Баянбилэг	2,702,213	20,267	2,702,213	20,267	2,722,480
8	Сосорбурам	3,806,250	82,087	3,806,250	82,087	3,888,337
9	Мөнхбат	3,750,000	167,876	3,750,000	167,876	3,917,876
10	Ш.Сандагочир	4,180,000	333,022	4,180,000	333,022	4,513,022
11	А.Мөнхбат	8,000,000	423,946	8,000,000	423,946	8,423,946
12	Ч.Отгонмөнх	2,204,302	16,532	2,204,302	16,532	2,220,834
13	Ж.Жигмэдсэнгээ	2,887,220	21,654	2,887,220	21,654	2,908,874
14	Ж.Эрдэнэбаатар	10,000,000	565,274	10,000,000	565,274	10,565,274
15	С.Хорлоо	4,829,932	20,930	4,829,932	20,930	4,850,862
16	Ө.Чимэд-Очир	3,750,000	169,521	3,750,000	169,521	3,919,521
17	А.Отгонгэрэл	4,065,545	30,492	4,065,545	30,492	4,096,037
18	Г.Цолмонбуд	2,985,616	22,392	485,616	22,392	508,008
19	Б.Нямдэлгэр	1,875,000	42,188	625,000	42,188	667,188
20	Ш.Ганбат	4,000,000	121,479	2,000,000	127,479	2,127,479
21	Д.Ёндон	6,000,000	182,219	3,000,000	182,219	3,182,219
22	Г.Мөнхбат	3,136,790	23,526	636,790	23,526	660,316
23	Б.Баярсайхан	970,296	-	220,296		220,296
24	Б.Бямбасүрэн	3,794,897	28,462	1,294,897	28,462	1,323,359
25	Б.Жавхлан	12,000,000	374,466	2,000,000	374,466	2,374,466
26	С.Батбаяр	2,512	-	2,512		2,512
27	Туяацэцэг	19,397	-	19,397		19,397
28	Х.Батжаргал	7,861		7,861		7,861
29	Ганболд	68,317		68,317		68,317
	Дүн	<b>97,811,223</b>	<b>3,189,238</b>	<b>73,311,223</b>	<b>3,195,238</b>	<b>76,506,461</b>
	Нийт дүн	<b>113,907,319</b>	<b>3,619,666</b>	<b>89,407,319</b>	<b>3,625,666</b>	<b>93,032,985</b>

ШАЛГАСАН АУДИТОР  Д.ДОЛЖИНСҮРЭН

ХЯНАСАН АУДИТЫН МЕНЕЖЕР  Х.НАРАНЦАЦРАЛ